

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.04.21

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Голомт банкны 2025 оны 1-р улирлын тайлан зарлагдлаа
- GLMT- авах эсвэл барих
- АХБ: Монгол Улсын эдийн засаг 2025 онд 6.6 хувиар өснө
- Ам.долларын ханш 3,600-д хүрлээ

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.01%	-4.30%	25.47%
MSE A	-0.8%	-4.40%	20.27%
MSE B	-1.01%	-4.80%	34.89%
2025/04/14 – 2025/04/18			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	483,269,995.00
CUMN	326,760,164.24
MSE	172,003,533.90
ERDN	151,327,215.00
GOV	129,709,749.71
2025/04/14 – 2025/04/18	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
UYN	1,390.00	51.09%
BODI	89.00	18.19%
SUU	590.00	17.23%
NGH	62.33	15.00%
TAH	16,200.00	14.89%
2025/04/14 – 2025/04/18		

2025 он 04-р сарын 21

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

11,770

ТОП-20 индекс

47,573

MSE A

17,411

MSE B

14,375



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.1%

2025-03 сар

ГВУН(сая\$)

4,995.97

2025-03 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

7.3%

USD/MNT

3,562.40

2025-04-20



Эдийн засгийн мэдээлэл

АМ.ДОЛЛАРЫН ХАНШ 3,600-Д ХҮРЛЭЭ



Дональд Трампын шинэ тарифын бодлоготой холбоотойгоор ам.долларын ханшийн индекс сүүлийн 2.5 жилийн доод түвшинд хүрч, хөгжиж буй орнуудын валютууд чангарлаа. Харин төгрөг ам.долларын эсрэг гурав дахь өдрөө дараалан суларч, 2023 оноос хойш анх удаа 3500 нэгжээс давлаа. Үүнээс гадна, Монгол Улсын 2025 оны эхний хоёр сарын төлбөрийн тэнцэл 742.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өмнөх оны ашигтай үзүүлэлтээс эрс дордсон байна.



АХБ:МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД 6.6%-ИАР ӨСНӨ

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны 2025 оны 4-р сард гаргасан тайланд дурдсанаар, Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9%-ийн өсөлт үзүүлсэн бол 2025 онд 6.6%, 2026 онд 5.9%-ийн өсөлттэй байх төлөвтэй байна.

Эдийн засгийн өсөлтөд уул уурхай, тэр дундаа Оюу толгойн зэсийн олборлолт, үйлчилгээний салбарын тэлэлт голлон нөлөөлөхөөр байгаа бол 2023–2024 онд хүндхэн байдалд байсан хөдөө аж ахуйн салбар энэ оноос аажмаар сэргэж эхэлнэ.

АХБ-ны ахлах эдийн засагч Эдуард Фэйберийн хэлснээр:

Уул уурхай, үйлчилгээний өсөлт нь хөдөө аж ахуйн агшилтыг нөхсөн. Цаашид уул уурхай эдийн засгийн гол хөдөлгүүр хэвээр үлдэж, дотоодын эрэлт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуйн сэргэлт нэмэлт дэмжлэг үзүүлнэ.”

Гэсэн хэдий ч эдийн засаг нүүрсний экспорт болон түүхий эдийн зах зээлээс өндөр хамааралтай хэвээр байгаа нь гол эрсдэл гэж анхааруулжээ.




Дотоодын зах зээлийн мэдээлэл

ГОЛОМТ БАНКНЫ 2025 ОНЫ 1-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Голомт Банк 2025 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлангаа танилцууллаа. Тайлант хугацаанд банк 117.5 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэ нь банкны үйл ажиллагааны үр ашиг дээшилж, ашигт ажиллагаа тогтвортой нэмэгдэж буйг илтгэж байна.

Тайлант хугацааны эцсийн байдлаар Голомт Банкны нийт хөрөнгө 15.4 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 49 хувийн өсөлт юм. Энэхүү огцом өсөлт нь банк хөрөнгийн төрөлжилт, эх үүсвэрийн оновчтой удирдлагыг эрчимтэй хэрэгжүүлсний үр дүн хэмээн үзэж болно. Үүнээс банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 1.39 их наяд төгрөгт хүрч, санхүүгийн тогтвортой байдлаа хадгалж байна.

Тэрбум төгрөг*



P/E	1.89
P/B	0.5
Хувьцааны ханш	1,029₮

Хөрөнгийн зах зээл дээрх үнэлгээг авч үзвэл, 2025 оны 4-р сарын 18-ны өдрийн хаалтын ханшаар тооцоход Голомт Банкны P/E үнэ, ашгийн харьцаа) 1.89, P/B харьцаа 0.5 байна. Эдгээр үзүүлэлт нь тус банкны хувьцаа нь одоогоор зах зээлд хямд үнэлэгдэж байгааг илтгэхийн зэрэгцээ ирээдүйд өсөх өндөр боломжтойг харуулж байна. Ялангуяа, TOP-20 индексэд багтдаг компанийн дундаж үнэлгээнээс доогуур байгаа нь хөрөнгө оруулагчдад боломж нээж байна.

Голомт Банкны хувьцааг АВАХ эсвэл БАРИХ стратегийг дараах шинжилгээний үр дүнд үндэслэн гаргасан болно.


- Банкнуудын хувьцаа бусад салбарын хувьцаанаас илүү доогуур үнэлэгдсэн;
- Үнэлгээний харьцаагаар банкнууд дунд Голомт Банк хамгийн доогуур үнэлэгдсэн буюу ирээдүйд ханш нь илүү өсөх боломжтой;
- Ашгийн өсөлт, активын өсөлт, өөрийн хөрөнгийн өгөөж системийн банкнууд дунд хамгийн өндөр бөгөөд зээлийн болон санхүүгийн эрсдэл бага;
- Гадаад зах зээлээс идэвхтэй санхүүжилт татаж байгаа нь эх үүсвэрийн өртөг буурахад нөлөөлсөн ба цаашид уг стратегийг үргэлжлүүлэхээр төлөвлөсөн;
- Урт хугацааны өсөлтийн боломжоо хадгалах, өөрийн хөрөнгийн хүрэлцээг өндөр байлгах зэргийг харгалзсан ногдол ашгийн бодлоготой, IPO үеийн төсөөллөө давсан ногдол ашиг хуваарилалттай;
- Хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх өндөр буюу тус банкны хувьцааг авч, зарахад хөрвөх чадварын асуудал үүсэхээргүй байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.